

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/62/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: <a href="mailto:sarantuyab@audit.gov.mn">sarantuyab@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: <a href="mailto:naranbayarg@audit.gov.mn">naranbayarg@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор Ц.Батсайхан Утас: 70543179 Цахим хаяг: <a href="mailto:batsaikhants@audit.gov.mn">batsaikhants@audit.gov.mn</a></p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК Захирал: Ш.Ичинхорлоо Утас: 77270808 Цахим хаяг: <a href="mailto:nitsbalance@gmail.com">nitsbalance@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3.Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	14
3.6.2 Төсвийн гүйцэтгэл .....	14
3.6.3 Нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Аудитын залруулга .....	16
4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.....	16
4.3 Албан шаардлага .....	16
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар

---





**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: govisumber@audit.gov.mn

Г АЙМГИЙН "ГЭР БҮЛ, ХҮҮХЭД,  
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН  
ГАЗАР"-ЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
Ц.ОЮУНБИЛЭГ ТАНАА

2022.02.25 № 29

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн "Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн "Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020039



5

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Б.Сарантуяа* Б.САРАНТУЯА



**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>21,293,280.28</b>	<b>9,287,257.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>560,028.00</b>	<b>3,451,528.00</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>560,028.00</b>	<b>3,451,528.00</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>560,028.00</b>	<b>3,451,528.00</b>
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	560,028.00	3,451,528.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,603,362.00</b>	<b>0.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	235,362.00	0.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>1,368,000.00</b>	<b>0.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	1,368,000.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>19,129,890.28</b>	<b>5,835,729.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>19,129,890.28</b>	<b>5,835,729.00</b>
35420	Аж ахуйн материал	19,129,890.28	5,835,729.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>78,560,127.08</b>	<b>69,284,635.78</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>78,560,127.08</b>	<b>69,284,635.78</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>58,741,752.08</b>	<b>50,269,760.74</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,500,000.00	18,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-5,395,833.24	-8,479,166.52
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	30,771,790.00	33,972,840.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-6,977,017.99	-13,291,792.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,908,730.00	27,298,820.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,539,916.69	-13,710,140.21
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,474,000.00	7,474,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-1,494,800.04
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>19,818,375.00</b>	<b>19,014,875.04</b>
39301	Програм хангамж	2,089,000.00	2,089,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-270,625.00	-1,074,124.96
39303	Бусад биет бус хөрөнгө	18,000,000.00	18,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>99,853,407.36</b>	<b>78,571,892.78</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>99,853,407.36</b>	<b>78,571,892.78</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>99,853,407.36</b>	<b>78,571,892.78</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	83,558,561.82	83,558,561.82
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-3,454,231.46</b>	<b>-24,735,746.04</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-8,528,128.09	-3,454,231.46
51220	Тайлант үеийн үр дүн	5,073,896.63	-21,281,514.58
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	19,749,077.00	19,749,077.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>99,853,407.36</b>	<b>78,571,892.78</b>



**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>244,603,948.00</b>	<b>285,442,551.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>14,731,548.00</b>	<b>10,577,051.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>14,731,548.00</b>	<b>10,577,051.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,488,624.00</b>	<b>3,431,400.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	337,746.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,150,878.00	3,431,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - ҮХ	6,970,424.00	2,641,240.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - БМ	6,272,500.00	4,504,411.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>229,872,400.00</b>	<b>274,865,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>197,361,700.00</b>	<b>208,873,900.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	197,361,700.00	208,873,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>18,662,300.00</b>	<b>52,143,200.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,129,000.00	835,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,533,300.00	51,308,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>13,848,400.00</b>	<b>13,848,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,848,400.00	13,848,400.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>239,530,051.37</b>	<b>306,724,065.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>239,530,051.37</b>	<b>306,724,065.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>238,315,524.45</b>	<b>268,275,602.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>127,117,509.00</b>	<b>120,008,420.00</b>
210101	Үндсэн цалин	53,284,341.00	76,305,730.00
210102	Нэмэгдэл	22,551,688.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	8,893,378.00
210104	Урамшуулал	0.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	51,281,480.00	34,809,312.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>16,194,451.00</b>	<b>15,341,193.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	12,448,767.00	10,767,993.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,003,366.00	1,143,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	765,732.00	915,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	179,690.00	228,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,796,896.00	2,285,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,331,475.08</b>	<b>15,400,408.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	897,264.08	747,110.00
210302	Түлш, халаалт	11,551,616.00	11,578,674.00
210303	Цэвэр, бохир ус	1,882,595.00	3,074,624.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>53,985,169.00</b>	<b>66,757,916.28</b>
210401	Бичиг хэрэг	3,102,640.00	24,869,615.00
210402	Тээвэр, шатахуун	4,401,000.00	6,091,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,147,560.00	1,173,310.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	0.00



210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	43,713,969.00	34,503,991.28
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>7,675,350.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	0.00	7,675,350.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,400,200.00</b>
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,400,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,550,411.00</b>	<b>621,064.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,306,347.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	279,100.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	41,064.00	41,064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	240,000.00
210807	Газрын төлбөр	37,900.00	18,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,636,509.37</b>	<b>41,071,051.30</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,310,850.00	25,614,420.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	590,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,525,659.37	14,866,631.30
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,214,526.92</b>	<b>38,448,463.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>250,000.00</b>	<b>23,062,100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	22,462,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	600,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>937,141.92</b>	<b>8,980,874.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	909,387.92	8,980,874.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	27,754.00	0.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>27,385.00</b>	<b>6,405,489.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,385.00	6,405,489.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>5,073,896.63</b>	<b>-21,281,514.58</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>5,073,896.63</b>	<b>-21,281,514.58</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,558,561.82	125,777.00	-8,528,128.09	57,156,210.73
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	65,558,561.82	125,777.00	-8,528,128.09	57,156,210.73
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	19,623,300.00	0.00	19,623,300.00



5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	18,000,000.00	0.00	0.00	18,000,000.00
6	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	5,073,896.63	5,073,896.63
7	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>83,558,561.82</b>	<b>19,749,077.00</b>	<b>-3,454,231.46</b>	<b>99,853,407.36</b>
8	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>83,558,561.82</b>	<b>19,749,077.00</b>	<b>-3,454,231.46</b>	<b>99,853,407.36</b>
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-21,281,514.58	-21,281,514.58
10	<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>83,558,561.82</b>	<b>19,749,077.00</b>	<b>-24,735,746.04</b>	<b>78,571,892.78</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>231,023,278.00</b>	<b>278,296,900.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,150,878.00</b>	<b>3,431,400.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,150,878.00</b>	<b>3,431,400.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,150,878.00</b>	<b>3,431,400.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,150,878.00	3,431,400.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>229,872,400.00</b>	<b>274,865,500.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>197,361,700.00</b>	<b>208,873,900.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	197,361,700.00	208,873,900.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	0.00	0.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>18,662,300.00</b>	<b>52,143,200.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,129,000.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,533,300.00	51,308,200.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>13,848,400.00</b>	<b>13,848,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,848,400.00	13,848,400.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>230,199,250.00</b>	<b>272,455,500.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>230,199,250.00</b>	<b>272,455,500.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>228,984,723.08</b>	<b>233,710,037.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>123,837,345.00</b>	<b>120,038,339.00</b>
210101	Үндсэн цалин	50,004,177.00	76,335,649.00
210102	Нэмэгдэл	22,921,348.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	8,893,378.00
210104	Урамшуулал	0.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	50,911,820.00	34,809,312.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>19,264,398.00</b>	<b>15,075,912.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,811,964.44	10,502,712.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,329,432.31	1,143,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,103,680.77	915,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	274,920.18	228,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,744,400.30	2,285,600.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,331,475.08</b>	<b>15,400,408.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	897,264.08	747,110.00
210302	Түлш, халаалт	11,551,616.00	11,578,674.00



210303	Цэвэр, бохир ус	1,882,595.00	3,074,624.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,548,500.00</b>	<b>6,309,960.00</b>
210401	Бичиг хэрэг	2,966,500.00	1,740,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,170,000.00	1,599,960.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,492,000.00	1,050,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>286,100.00</b>	<b>190,700.00</b>
210604	Урсгал засвар	286,100.00	190,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,400,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,400,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>54,879,122.00</b>	<b>621,064.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,635,058.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	279,100.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	41,064.00	41,064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	240,000.00
210807	Газрын төлбөр	37,900.00	18,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,337,783.00</b>	<b>74,673,454.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,310,850.00	73,690,954.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,026,933.00	982,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,214,526.92</b>	<b>38,745,463.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>250,000.00</b>	<b>23,359,100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	22,462,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	897,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>937,141.92</b>	<b>8,980,874.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	909,387.92	8,980,874.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	27,754.00	0.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>27,385.00</b>	<b>6,405,489.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,385.00	6,405,489.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>824,028.00</b>	<b>5,841,400.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>264,000.00</b>	<b>2,949,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>264,000.00</b>	<b>2,949,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>264,000.00</b>	<b>2,949,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	264,000.00	2,949,900.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-264,000.00</b>	<b>-2,949,900.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>560,028.00</b>	<b>2,891,500.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	560,028.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	560,028.00	3,451,528.00



**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>222,722,300.00</b>	<b>216,316,811.00</b>	<b>6,405,489.00</b>	<b>97.1</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>222,722,300.00</b>	<b>216,316,811.00</b>	<b>6,405,489.00</b>	<b>97.1</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>199,360,200.00</b>	<b>192,957,711.00</b>	<b>6,402,489.00</b>	<b>96.8</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>114,380,000.00</b>	<b>108,804,338.00</b>	<b>5,575,662.00</b>	<b>95.1</b>
210101	Үндсэн цалин	65,180,100.00	65,101,648.00	78,452.00	99.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,584,000.00	8,893,378.00	1,690,622.00	84.0
210105	Гэрээт ажлын хөлс	38,615,900.00	34,809,312.00	3,806,588.00	90.1
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>14,295,500.00</b>	<b>14,019,715.00</b>	<b>275,785.00</b>	<b>98.1</b>
210201	Тэтгэврийн даатгал	9,722,300.00	9,446,515.00	275,785.00	97.2
210202	Тэтгэмжийн даатгал	1,143,800.00	1,143,800.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	915,000.00	915,000.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	228,800.00	228,800.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,285,600.00	2,285,600.00	0.00	100.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,657,700.00</b>	<b>13,657,700.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	807,200.00	747,110.00	60,090.00	92.6
210302	Түлш, халаалт	11,447,600.00	10,598,674.00	848,926.00	92.5
210303	Цэвэр, бохир ус	1,402,900.00	2,311,916.00	-909,016.00	164.8
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,230,000.00</b>	<b>4,229,960.00</b>	<b>40.00</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	990,000.00	990,000.00	990,000.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,800,000.00	1,800,000.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.00	999,960.00	999,960.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00	120,000.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	320,000.00	320,000.00	320,000.00	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>190,700.00</b>	<b>190,700.00</b>	<b>190,700.00</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	190,700.00	190,700.00	190,700.00	100.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,400,200.00</b>	<b>1,400,200.00</b>	<b>93.3</b>
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,400,200.00	1,400,200.00	93.3
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>719,000.00</b>	<b>621,064.00</b>	<b>621,064.00</b>	<b>86.3</b>
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00	300,000.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,000.00	41,064.00	41,064.00	40.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	22,000.00	22,000.00	62.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	264,000.00	240,000.00	240,000.00	90.9
210807	Газрын төлбөр	18,000.00	18,000.00	18,000.00	100.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>50,387,300.00</b>	<b>50,034,034.00</b>	<b>50,034,034.00</b>	<b>99.3</b>



210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,400,000.00	49,051,534.00	49,051,534.00	99.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	987,300.00	982,500.00	982,500.00	99.5
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,362,100.00</b>	<b>23,359,100.00</b>	<b>23,359,100.00</b>	<b>99.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>23,362,100.00</b>	<b>23,359,100.00</b>	<b>23,359,100.00</b>	<b>99.9</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,462,100.00	22,462,100.00	22,462,100.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	897,000.00	897,000.00	99.6
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>222,722,300.00</b>	<b>216,316,811.00</b>	<b>216,316,811.00</b>	<b>97.1</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>208,873,900.00</b>	<b>202,468,411.00</b>	<b>216,316,811.00</b>	<b>96.9</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00	13,848,400.00	0.0
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	208,873,900.00	202,468,411.00	202,468,411.00	96.9
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>13,848,400.00</b>	<b>13,848,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
320001	Орон нутгийн төсвөөс	13,848,400.00	13,848,400.00	0.00	100.0
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>25.00</b>	<b>25.00</b>	<b>0.00</b>	<b>25.0</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>0.0</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	0.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>12.00</b>	<b>12.00</b>	<b>0.00</b>	<b>0.0</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	0.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00	0.00	0.0
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00	0.00	0.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>12.00</b>	<b>12.00</b>	<b>0.00</b>	<b>0.0</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>52,143,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>52,143,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>43,162,326.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>11,234,001.00</b>
210101	Үндсэн цалин	11,234,001.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,056,197.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,056,197.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,742,708.00</b>
210302	Түлш, халаалт	980,000.00
210303	Цэвэр, бохир ус	762,708.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,080,000.00</b>
210401	Бичиг хэрэг	750,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	730,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,049,420.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,049,420.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,980,874.00</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,980,874.00</b>



213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	8,980,874.00
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>52,143,200.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>52,143,200.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,308,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хангамж, бараа материалын данс болон төсвийн зарцуулалттай цахим төлбөрийн баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-ийн аудитор Ц.Энхтуяа гүйцэтгэж, чанарын анхан шатны хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Наранбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэрийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Гэр бүл, хүүхэд залуучуудын талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлж, хүүхэд залуучуудын ёс зүй, хөгжил оролцоог эрхэмлэж, хамгааллын үйлчилгээг үзүүлнэ” гэж тодорхойлж, үйл ажиллагааны дараах зоритуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Гэр бүлийн хөгжил, дэмжин олон талт арга хэмжээг зохион байгуулах;
- Хүүхдийн эрх, Хөгжил хамгаалал, оролцооны үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх, хүүхдийн эрхийг хатгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх;
- Залуучуудын хөгжил нийгмийн оролцоог дэмжих, соён гэгээрүүлэх, сэтгэлгээг өөрчлөх, хуулийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;



- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шлгалт хийгдээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх баталсан төсвийн нийт зардлын хүлээгдэж буй гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд ерөнхий материаллаг байдлыг 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх баталсан төсвийн нийт зардлын хүлээгдэж буй гүйцэтгэл 216,316.8 мянган төгрөгийн 2.0 хувь буюу 4,326.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувь буюу 3,028.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.



### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21.2 хувь буюу 21,281.5 мянган төгрөгөөр буурсан ба өмнөх оны үзүүлэлтээс материаллаг хэмжээний өөрчлөлттэй авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,603.3	-	(1,603.3)
Бараа материал	19,129.9	5,835.8	(13,294.1)
Үндсэн хөрөнгө	78,560.1	69,284.6	(9,275.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>99,853.4</b>	<b>78,571.9</b>	<b>(21,281.5)</b>
Богино хугацаат ер төлбөр			
Засгийн газрын оролцоо /ЭӨ/	99,853.4	78,571.9	(21,281.5)
<b>Нийт ер төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>99,853.4</b>	<b>78,571.9</b>	<b>(21,281.5)</b>

Авлагын дансны эхний үлдэгдэл 1,603.3 мянган төгрөгийг бүрэн барагдуулсан ба тайлант онд шинээр авлага үүсгээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5,835.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,294.1 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал, түлш шатах тослох материал, бичиг хэргийн материалын зардал багассантай холбоотой ба тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 55,341.3 мянган төгрөгийн бараа материалыг худалан авч, 4,504.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч бүртгэж, тайлагнасан ба үйл ажиллагаандаа 73,140.0 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 69,284.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 9,275.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлаас шалтгаалсан ба тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 2,949.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, 2,641.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилгыг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 78,571.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 21,281.5 мянган төгрөгөөр буурахад тайлант үеийн үр дүн нөлөөлжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого 285,442.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 40,838.6 мянган төгрөгөөр буюу 16.6 хувиар өссөн нь тусгай зориулалтын шилжүүлэг 7,9 хувь буюу 15,512.2 мянга, нэмэлт санхүүлтийн орлого 1,8 дахин буюу 33,480.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үйл ажиллагааны зарлага өмнөх оноос 28.0 хувиар буюу 67,194.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа, ажил үйлчилгээний зардал 29,960.0 мянга, урсгал шилжүүлгийн зардал 37,233.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 210,237.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв батлахдаа улсын төсвийн санхүүжилтийг 210,237.8 мянган төгрөгөөр баталсан ба 2021 оны төсвийн тодотголоор улсын төсвийн санхүүжилтийг 13,848.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 224,086,2 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр “үндсэн үйл ажиллагааны арга хэмжээ”-ний санхүүжилтийг 222,722.3 мянган төгрөгөөр баталсан ба үүнээс улсын төсвийн 202,468.4 мянга, орон нутгийн төсвийн 13,848.4 мянга, нийт 216,316.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Баталсан нийт төсөвт зардлын гүйцэтгэл 216,316.8 мянган төгрөг болж, 3.5 хувиар хэмнэгдсэн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 5,575.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 93.7 мянга, бараа үйлчилгээний зардал 353.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээрэнэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчаас 51,308.2 мянга, төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс авсан хандив, тусламж 800.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 35.0 мянга, нийт 52,143.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 11,234.2 мянга, НДШ-н зардалд 1,056.1 мянга, байр ашиглалттай холбоотой зардалд 1,742.7 мянга, хангамж, бараа материалын зардалд 2,080.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 27,049.4 мянга, төвлөрүүлэн шилжүүлгийн зардалд 8,980.8 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Говьсүмбэр аймаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 73 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь 94.0 хувийн биелэлттэй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал, стандарт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй тул санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй гэж үзлээ.



### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т “хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх” зохицуулалттай байна.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 2021 онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 149 мэдээллийг байршуулахаас 149 мэдээллийг байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээ, худалдан авалтын цахим төлбөрийн баримтын системийн хэрэгжилт нь Засгийн газрын тогтоол болон, Татварын ерөнхий хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар өгсөн 1 албан шаардлага, 2 зөвлөмж, 1 төлбөрийн актын хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитын нийт 45,406.5 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрсэн бөгөөд алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх тухай 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн болно. Залруулагдаагүй 37,811.0 мянган төгрөгийн алдаа зөрчил тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшинээс их дүнтэй боловч санхүүгийн тайланд нөлөөлөлгүй учир “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.



#### **4.1 Аудитын залруулга**

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа залруулга хийгдээгүй.

#### **4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.**

#### **4.3 Албан шаардлага**

Тайлант хугацаанд 7,595.5 мянган төгрөгийн худалдан авалтын төлбөрийн баримтыг цахим төлбөрийн баримтын системд шивүүлж, баталгаажуулаагүй, Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Хангамж, бараа материалын данстай холбоотой асуудал**

###### 1.1 Илрүүлэлт:

Холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр шуудан холбоо, интернетийн зардлаас 411.7 мянга, урсгал засварын зардлаас 190.7 мянга, бараа ажил, үйлчилгээний бусад зардлаас 33,766.7 мянга, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 195.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 297.0 мянга, нийт 34,861.1 мянган төгрөгийн бараа материалыг тус тус бэлтгэж, баталсан төсөвт зардлыг бүлэг хооронд шилжүүлж зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй байна.

###### 1.2 Өгсөн зөвлөмж:

Баталсан төсвийг зориулалт бусаар, бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтны шийдвэрийг гаргуулан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан зарцуулах эрх авах.

##### **2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

###### 2.1 Илрүүлэлт:

Бараа материалын зардлаас 2,949.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн ба “ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### 2.2 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.



Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

		/мянган төгрөгөөр/									
д/д	Алдаа зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Зал-руулга		Төлбө-рийн акт		Үүнээс Албан шаард-лага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитаар											
1	Бараа материалын данснаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн.	1	2,949.9							1	2,949.9
2	Холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр шуудан холбоо, интернетийн зардлаас 411.7 мянга, урсгал засвараас 190.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 33,766.7 мянга, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 195,0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулал зардлаас 297,0 мянга, нийт 34,861.1 бараа материалыг бэлтгэж, зардлыг бүлэг хооронд шилжүүлсэн	1	34,861.1							1	34,861.1
Санхүүгийн тайлангийн аудитаар хийсэн нийцлийн аудитаар											
3	Тайлант хугацаанд хийсэн худалдан авалтын төлбөрийн баримтыг цахим төлбөрийн системд 7,595.5 мянган төгрөгөөр дутуу буюу шивэгдээгүй, худалдан авалт хийгээгүй байгууллагуудаас баримт илүү шивэгдсэн	1	7,595.5						1	7,595.5	
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>3</b>	<b>45,406.5</b>						<b>1</b>	<b>7,595.5</b>	<b>2</b>
											<b>37,811.0</b>





ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 63/А0860273  
ГА-2022/62/СГА-ТМБ

Чойр

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн аймгийн "Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газар"-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант хугацаанд хийсэн зарим худалдан авалтын 7,595.5 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг цахим төлбөрийн баримтын системд шивүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтад "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**



1. Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллах, худалдан авалтын үнийн дүн зөрүүтэй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх;

<sup>1</sup> Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543156



- 2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн "Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газар"-ын дарга Ц.Оюунбилэг, нягтлан бодогч Д.Оюунцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ГЭРЭЭТ АУДИТОР		Ц.ЭНХТУЯА
АХЛАХ АУДИТОР		Ц.БАТСАЙХАН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Б.САРАНТУЯА

421714445  
УСА0055 90 9049